

ХОРИГДЛЫН ШАШИН ШҮТЭХ, ЭС ШҮТЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

IMPLEMENTATION OF PRISONERS' RIGHT TO RELIGION AND NON- RELIGION AND ISSUES TO BE CONSIDERED

Б.Өсөхбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Сургалт судалгааны 403 дугаар анги-шшгас-ийн 541 дүгээр дамжааны дэд түрүүч;

Хураангуй: Илтгэлээр хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийн мөн чанар, ач холбогдлыг тайлбарлан хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хоригдлын шашны зан үйл үйлдэх, өөр өөр шашны итгэл үнэмшил бүхий хоригдлын хэрэгцээг тэнцвэртэй хангахад чиглэсэн шийдлийг санаачлахыг зорьсон. Судалгааг хууль зүйн шинжлэх ухааны баримт бичгийн дүн шинжилгээ, харьцуулах судлах, анализ, синтез, түүвэрлэн судлан анкетын аргуудыг ашиглан гүйцэтгэсэн бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхэд хандаж буй нийтлэг хандлага, хүний эрхийн зөрчлийг тодорхойлсон болно.

Abstract: The report explained the nature and importance of the human right to religion and non-religion, identified the need and requirements for preventing human rights violations during imprisonment, and sought to initiate a solution aimed at balancing the needs of prisoners. with different religious beliefs and performing religious rituals. The study was conducted using methods of analysis of legal and non-religious documents, comparative research, analysis, synthesis, sampling and questionnaires and determined the general attitude towards the religious and non-religious rights of the prisoner in the judicial decision-making body, namely: as well as violations of human rights.

Түлхүүр үг: Хоригдол, шашин, хүний эрх, шашны зан үйл үйлдэх, шашны зан үйл үйлийн өрөө, хэрэгцээ, зөрчил, нийгэмшүүлэх ажил, хууль зүй.

Key words: Prisoners, religion, human rights, religious practice, religious practice rooms, needs, violations, social work, jurisprudence.

Оршил

Хүний эрхийг хязгаарлах хэрэгцээ, шаардлагыг нийгмийн гишүүд нийтээрээ хүлээн зөвшөөрдөг хэдий ч ямар эрхийг ямар тохиолдолд, хэрхэн яаж хязгаарлах хүрээ, хэмжээг тогтоох тухай асуудалд анхааралтай хандах хэрэгтэй. Учир нь хүн хэмээх байгалийн бодгал нь итгэл үнэмшил, үзэл бодол буюу оюун санааны дархлааг тогтоосноор хүн хэмээх шинж чанараа хадгалж үлддэг билээ.

Хүн төрөлхтний хөгжлийн үе шатыг авч үзвэл тэдний итгэл үнэмшил, үзэл санаа нь хүний нийгмийг, нийгмийн тогтолцоог хөгжүүлэх үндсэн хөшүүрэг болж

ирсэн түүхтэй. Энэ нь нэг талаасаа хувь хүний бие даасан, тусгаар тогтносон байдлыг илэрхийлэх ойлголт болж байна. Үүний нэг томоохон илрэл нь шашны эрх чөлөөгөөр тодорхойлогдож байгаа бөгөөд шашин шүтэх, эс шүтэх эрхийг хангах нь тухайн хүний мөн чанарыг хүлээн зөвшөөрөх, оюун санааны дархлаа болдог онцлогтой. Хэдийгээр манай улс иргэнийхээ шашны эрх чөлөөг нээлттэй хангах асуудлыг Үндсэн хууль хийгээд дотоодын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажуулсан боловч эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн хувьд уг эрх чөлөөний асуудал хөндөгдөх болоод байна.

Учир нь хорих ял эдлүүлэх ажиллагаа нь тухайн гэмт этгээдийг олон нийтээс тусгаарлаж түүний гэмт зан үйл, хандлага, дадлыг хорьж засахад чиглэсэн арга хэмжээ билээ. Дэлхий дахинд шашин болон түүнд хандах хүмүүсийн итгэл үнэмшил нь гүн гүнзгий утгатай ойлголт бөгөөд түүнд халдах, итгэл үнэмшлийг няцаах, хясан боогдуулах нь маш ноцтой үр дагавруудад хүргэж болохыг дэлхийн түүх бидэнд харуулсаар ирсэн.

Иймд хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхийн хэрэгжилт, агуулгад дүн шинжилгээ хийж, хорих ял эдлүүлэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх улмаар ял эдлүүлэх ажиллагаан дахь хүний эрхийн хэрэгжилтийг хангахад илтгэлийн агуулга чиглэгдэнэ. Үүний тулд илтгэлийн агуулгыг шашин шүтэх, эс шүтэх эрх, түүний хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт, түүний үзэл санааны хүрээнд судлахыг зорилоо.

Үндсэн хэсэг

Шашны талаар авч үздэг олон үзэл хандлага, номлол, сургаал, эрдэмтдийн тодорхойлолт байдаг. Мөн шашныг нийгмийн талаас, философиин үүднээс, эрх зүйн үүднээс хэлзүйн үүднээс гээд олон өнцгөөр тайлбарлаж болно. “Шашин” хэмээх ойлголтыг тодорхойлолтуудыг авч үзвэл Шашин нь хүмүүсийн үйлддэг, аливаа номлолыг дагадаг сүсэг бишрэл, ёс суртахуунуудыг хэлнэ¹. “Шашин нь бурхан эсвэл бурхад байдаг гэдэгт итгэх итгэл, тэднийг шүтэн бишрэх зан үйл эсвэл сүнслэг удирдагчийн сургаал”² юм гэж тодорхойлсон байдаг. Мөн Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд шашныг “Бурхан сүнс гэх мэтийн ер бусын хий хоосон зүйлд шүтэх бишрэх тэргүүтний цогц болох үзэл суртлын нэг зүйл давхрага”³ гэж тайлбарлажээ. Харин Үндэсний статистикийн хорооноос 2020 онд гаргасан “Сүм хийдийн салбарын танилцуулга”-д “Шашин шүтлэг нь хүн төрөлхтөн үүсч, оршин тогтносон цагаасаа өөрсдийн амьдралд бий болгосон дэлхий дахины нийтлэг үзэгдэл бөгөөд шашныг ертөнцийг үзэх үзэл, оюун санааны учрыг тайлах, хүн төрөлхтний итгэл үнэмшил, сүсэг бишрэлийн цогц”⁴ гэж тодорхойлсон байна.

¹ <https://mn.wikipedia.org/wiki/>

² <https://www.oxfordlearnersdictionaries.com/>

³ Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь <https://tsevel.toli.query.mn/>;


⁴ Үндэсний статистикийн хороо. Сүм хийдийн салбарын танилцуулга. 2020 он. УБ хот. 5 дахь нүүр.

Эдгээрээс үзвэл шашин гэдэг нь хүний аливаад итгэх итгэл, сүсэг бишрэл бөгөөд уг итгэл үнэмшлийнхээ хүрээнд тодорхой зан үйл үйлдэх байдал гэж ойлгож болох юм. Нэг үгээр хүний зан үйлийн салшгүй нэг хэсэг болох нь харагдаж байна.

Шашин нь танин мэдэхүйн хэлбэрээр байгаль нийгмийн үзэгдлийг тайлбарлах замаар хөгжиж ирсэн ч өдгөө хүний мөн чанар, оюун санааны дархлааг тогтоох хүмүүнлэг хийгээд хүмүүжлийн хэрэгсэл болоод байна. Шашин нь өөртөө сүм хийд, лам хуврага, сургааль номлол зэрэг олон ойлголтуудыг багтаасан өргөн хүрээтэй ухагдахуун юм. Шашин шүтлэгийн анхны хэлбэрүүд одоогоос 100-40 орчим мянган жилийн тэртээ Неандарталь /анхны ухаант хүн/ хүмүүсийн үед үүссэн гэж хэд хэдэн түүхэн эх сурвалжуудад дурдсан байна.

Дэлхий дээр 4000 гаруй шашин, шашны урсгал байна гэсэн тооцоолол байдаг¹. Эдгээрээс дэлхийн хүн амын дийлэнх олонхи нь Христ, Ислам, Буддизм, Хинду, Йудайн гэсэн үндсэн таван шашинд сүсэглэдэг хэмээн судлаачид ангилсан байна. Буддизм, Ислам, Христийн шашин нь өөрийн сүм, лам, номлогч, мөргөл, буян үйлдэх тусгай зан үйлтэй байдаг. Эдгээрээс үзэхэд шашин болгон өөрийн үзэл баримтлал, итгэл үнэмшилд суурилсан тус тусын зан үйлийн хэлбэрээр илэрхийлэгддэг.

График №1. Олон улсын PEW судалгааны төвөөс 2023 онд гаргасан шашны томоохон бүлэглэлүүдийн дэлхийн нийт хүн амд эзлэх хувийг харуулсан судалгаа²:



Уг судалгаанаас харахад 2023 оны байдлаар дэлхийн нийт хүн ам болох 8.02 тэрбум³ хүнээс огт шашин шүтлэггүй нь 15,1% болох 1.2 тэрбум орчим, шашин шүтлэгтэй хүн амын тоо нийт хүн амын 84,4% буюу 6.82 тэрбум хүнийг хамарч байгааг харж болно.

¹ <https://www.caaknews.mn/view/8303808>

² Pew судалгааны төвийн Шашин ба нийтийн амьдрал төсөл. Pew Research Center's Religion & Public Life Project. 2012 он. <https://www.pewresearch.org/religion/2012/03/22/pew-forum-releases-new-50-state-survey-of-prison-chaplains/>

³ <https://www.statista.com/statistics/805044/total-population-worldwide/>, Сүүлд нэвтэрсэн: 2024.10.31 19:35 минут

Дэлхийн шашин шүтлэгтэй хүн амын 30,7% буюу 2.61 тэрбум орчим хүн Христийн шашныг шүтэж байгаа нь дэлхийн хамгийн нөлөө бүхий шашны урсгалд тооцогдож байгааг харуулж байна. Удаах байранд Ислам, Хинду, Будда буюу буддын шашин хамаарч байна.

Эдгээр нь хүн ялангуяа хүний хүмүүжил, төлөвшилд шашны үзүүлэх нөлөө, байр суурийг ямар гүн бат болохыг харуулж байна. Энэ ч утгаараа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хуулиар баталгаажуулсан орон болохын хувьд хүмүүс өөрсдийн шүтэх шашнаа чөлөөтэй сонгох эрхтэй.

2020 оны судалгаагаар Монголчуудын 51.8 хувь нь Будда, 3.2 хувь нь Ислам, 2.5 хувь нь Бөө, 1.3 хувь нь Христ, 0.6 хувь нь бусад шашин шүтдэг гэжээ.¹ Үүнээс харахад нэг төрлийн шашны үзэл, хандлагыг хүлээн зөвшөөрөх нь нийгмийн гишүүдийн тэгш байдлыг хангах боломжгүйд хүргэх эрсдэлтэй байгааг тодорхойлж байна. Мөн үндэсний статистикийн хорооноос 2 жил тутам гаргадаг “Сүм хийд” танилцуулгын 2024 оны дугаараас Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сүм хийдийн тоог, шашны төрлөөр нь ялган харуулсан судалгааг авч үзье.

График №2. Үндэсний статистикийн хорооноос гаргасан Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сүм хийдийн тоог, шашны төрлөөр ялган харуулсан судалгаа².




График №3. Монгол Улсын хэмжээнд сүм хийдийн эзлэх хувь

¹ АНУ-ын Элчин сайдын яам, “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан – Монгол Улс 2019,” <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-international-religious-freedom-report-mn/> ; “Хүн ам,” Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.1212.mn/haos/haoscount.aspx>

² Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Сүм хийдийн танилцуулга. 2024 он. https://downloads.1212.mn/0gCx-43Y3KuFRrtz-eM_ErwDgZWBXI6AX4sF8y7l.pdf



Судалгаанаас үзвэл 2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 371 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оноос 25 (7.2%)-аар өссөн тоон үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Христийн шашны урсгалын сүм хийдийн тоо тэргүүлж байгаа бөгөөд Буддын шашны сүм хийдийн тоо өсөх хандлагатай байна. Нийт сүм хийдийн 56.3 хувь нь Христийн, 35.6 хувь нь Буддын, 6.2 хувь нь Исламын, 1.9 хувь нь бусад төрлийн шашных байна.¹

Хүний эрхийн түгээмэл тунхаглал²-ын 18 дугаар зүйлд “Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана” гэж тодорхойлсон нь шашин шүтэх эрхийг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх хэрэгцээг тодорхойлж өгсөн явдал юм.

Монгол Улсад төр, сүм хийдийн харилцаанд баримтлах зарчмыг Үндсэн хуулиар тогтоож өгсөн ба дараах байдлаар тодорхойлсон. Үндсэн хуулийн 9.1-д “Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ,” 9.2-т “Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй,” 9.3-т “Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна” гэж тусгайлан заасан. Мөн, төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулахдаа Үндсэн хуулийн 16.15, 16.6-д хүлээн зөвшөөрсөн “шашин шүтэх, эс шүтэх,” “итгэл үнэмшилтэй байх” эрх чөлөө, Үндсэн хуулийн 1.2-т “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх” зарчмыг хүндэтгэх үүрэгтэй. Жишээлбэл, төр аливаа шашны маргаанд аль нэг талд тал засах, тодорхой шашны байгууллага эсхүл түүний удирдагчийн талд орох, шашны байгууллагыг бүртгэхэд хэлбэрийн бус агуулгын шаардлага тавих зэрэг нь төвийг сахиагүй хэрэг тул тэгш байдлыг зөрчинө. Мөн, шашин хоорондын аливаа ялгаа нь

¹ Мөн тэнд

² Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. <https://legalinfo.mn/mn/detail/1271>

зүй ёсны объектив хүчин зүйл, үндэслэлээр зөвтгөгдөх бөгөөд ялгаварласан хандлага гаргахгүй байх шаардлагатай. Учир нь, Үндсэн хуулийн 14.1-д “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна,” “Хүнийг... шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан тул төрөөс шашин эсхүл итгэл үнэмшлийн эрх чөлөөг ямар ч ялгаварлан гадуурхалгүйгээр эдлүүлэх ёстой¹. Энэ шашин шүтэх эрх болон тэрхүү эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, хангах асуудал нь нийгмийн суурь харилцаа болохыг нэмэн тодотгосоор байна.

Тэгвэл уг эрх нь юм, үзэгдлийн мөн чанар, учир шалтгааныг тайлбарладаг тодорхой номлол, сургаалыг өөрийн дотоод сэтгэл, итгэл үнэмшлээрээ эрхэмлэн дээдлэх, түүний дагуу зан үйлийг нь бусдын албадлага, хязгаарлалтгүйгээр, нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээний хүрээнд гүйцэтгэх боломж хэмээн авч үзэж болно. Шашин эс шүтэх эрх чөлөө гэж Монгол Улсын иргэн юм, үзэгдлийн мөн чанар, учир шалтгааныг тайлбарладаг тодорхой номлол, сургаалыг өөрийн итгэл үнэмшил болгохоос татгалзах, бусдын албадлага, шахалтаар хүлээн зөвшөөрөх, зан үйлийг нь гүйцэтгэх шаардлагаас хамгаалагдах боломж² хэмээн тодорхойлсон байна.

Уг үзэл баримтлалын хүрээнд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль³-д “Шашны зан үйлийг тухайн шашны уламжлалт ёс журмын дагуу энэ хууль, бусад хууль тогтоомжоор тусгайлан хориглоогүй газарт сүсэгтний хүсэлтээр тэдэнд зориулж чөлөөтэй үйлдэж болно” хэмээн заасан байдаг ба хорих ял эдлүүлэх ажиллагаанд ч мөн адил хоригдлын шашны зан үйл үйлдэх боломжийг хорих байгууллагын зүгээс хангаж өгөх шаардлагатай болохыг тодорхойлж байна.

Ийнхүү шашин нь хувь хүн болон нийгмийн сэтгэл зүй, ёс зүй, дэг жаяг, амьдралын хэв маягтай уялддаг тул өөр өөр шашин шүтлэгтэй хүмүүсийн хооронд сэтгэл зүй, ёс зүй, нийгэмд мөрдөх дэг ёс, амьдралын хэв маягийн ялгааг хувь хүн, нийгмийн бүлэг, институциуд харилцан ойлголцох, харилцан хүлээн зөвшөөрөх нь чухал болохыг харуулж байна.

¹ Монгол Улсын Их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн. “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” (Эмхэтгэл). О.Мөнхсайхан “Итгэл үнэмшилтэй байх шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө” өгүүлэл. 2022 он. 52 дахь тал.

² ХЭҮК, Залуу судлаачдыг дэмжих сан ТББ. Монгол улсын үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт туссан хүний эрхийн заалтуудад системийн инженерчлэлийн аргаар тодорхойлолт боловсруулах нь судалгааны тайлан. УБ хот, 2024 он, 55 дахь тал.

“Хүний эрхийн нэр томьёонд системийн инженерчлэлийн аргаар тодорхойлолт боловсруулах нь” судалгааны ажлыг “Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын нийт 12 судлаачийн багийн бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 2024 оны 3 дугаар сарын 31-ний хооронд нийт 11 сарын хугацаанд 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн байна.

³ Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1993 он. №06-07

Харин хорих байгууллагын хувьд уг эрхийн агуулгыг тодорхойлохдоо Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм /Манделийн дүрэм/д¹ “Хорих газарт аль нэг шашныг шүтдэг хангалттай тооны хоригдол байвал тухайн шашны мэргэжлийн ламыг томилох буюу хорих газарт зохих зан үйл явуулах зөвшөөрөл олговол зохино. Хэрэв ийм хоригдол их олон бөгөөд боломжтой бол ламыг байнга ажиллуулахаар томилно. Томилогдсон буюу зөвшөөрөгдсөн мэргэжлийн лам нь шашны зан үйлийг тогтоосон цагт байнга явуулах, тухайн шашныг шүтдэг хоригдолтой ганцаарчлан уулзаж, шашны сэдвээр ярилцах боломжтой байх ёстой. Аль ч шашны мэргэжлийн ламтай хоригдол уулзах боломжийг хязгаарлаж болохгүй. Нөгөө талаас хоригдол ламтай уулзахыг эсэргүүцвэл түүний хүсэлтэд бүрэн хүндэтгэлтэй хандах ёстой. Хоригдол бүр хэрэгжүүлж болох хүрээнд шашны зан үйл явуулахад оролцож, өөрийн шашны ном зохиолтой байж шашны хэрэгцээгээ хангах боломжтой байх ёстой гэж заасан байдаг.

Үүнээс үзвэл уг харилцааг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомжоор эдгээр эрхийн агуулгыг тодорхойлох ёстой болохыг сануулж байна. Манай улсын хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль²-аар хоригдлын шашны зан үйл үйлдэх эрхийг хүлээн зөвшөөрсөн.

Гэсэн хэдий ч хүний эрхийн үүднээс нарийвчлан авч үзвэл хоригдын уг эрхийн хэрэгжилтэд тодорхой асуудлууд үүссээр байгааг анхаарах судлах, шийдэл саналуудыг санал болгох шаардлага байгааг онцлох хэрэгтэй.

Шашны зан үйл үйлдэх нь хүний сэтгэл зүй, ёс суртахуун, нийгэмшил, зан үйл, хандлагын төлөвшилд эерэг нөлөөтэй болох нь судалгаагаар тодорхойлогддог.

Монгол Улсад хорих ял эдлүүлэх ажиллагааны салбарт шашин шүтэх эрхийг төдийлөн чухалчлан авч үзэхгүй байх, хэлбэрийн түвшинд уг эрхийг хангах зэрэг өрөөсгөл хандлага оршсоор байгааг дурдах хэрэгтэй. Ингэснээр хэдийгээр хорих ял эдэлж байгаа тухайн хүний эрхийг хязгаарлах шалтгаан болж байгаа хэдий оюун санаа, итгэл үнэмшлийн хувьд гадуурхагдах, эрхээ хязгаарлуулах шалтгаан болоод байна. Нэг үгээр итгэл үнэмшлийг нь ойлгож хүндэтгэхгүй байх нь тухайн хүний олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх, хүндлэгдэх хэрэгцээ шаардлагыг үгүйсгэж байгаа ноцтой зөрчил болно. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд уг эрхийг чухалчлан авч үзэхгүй байгаа нь хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилго, хоригдлын нийгэмшүүлэх хэрэгцээ шаардлагад харш үйл ажиллагаа болоод байгааг нийтэд анхааруулах, түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй болсныг сануулж байна.

¹ Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм. 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр их хурлаар баталж, эдийн засгийн болон нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 C/XXIY/ 1977 оны 5 дугаар сарын 13-ны 2076 /1X11/ тогтоолд сайшаав.

² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24. 2017 он.

“Хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхийн хэрэгжилтийн талаарх судалгаа”-г 2024 оны 10 дугаар сарын байдлаар хорих ял эдэлж буй хоригдлуудаас анкетын аргаар түүвэрлэн авч, нэгтгэсэн юм.

Судалгаанд ШШГЕГ-ын харьяа 3 хорих ангийн нийт 183 хоригдол хамрагдсан бөгөөд эдгээрээс 84 эмэгтэй, 99 нь эрэгтэй хоригдлууд оролцсон байна.

График №4. Хоригдлын шашин шүтэх шүтлэгийн хувийг харуулсан судалгаа



Судалгаанд хамрагдсан нийт хоригдлуудын 87% нь шашин шүтдэг, 23% нь шашингүй гэж хариулсан байна. Эдгээрийг задлан авч үзвэл буддын шашинтай гэж 44%, бөө мөргөлийн шашинтай 18%, Христийн шашинтай 10%, Исламын шашинтай гэж 3%, бусад шашныг шүтдэг гэж 2% нь тус тус хариулсан байна.

График №3. Хорих ангиудад байх шашны өрөөний нөхцөл



Дээрх судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан хоригдлуудын 72% нь хорих ангийн шашны өрөө нь буддын шашны зан үйл үйлдэхэд тохиромжтой байдлаар тохижуулагдсан байдаг гэж хариулсан байна.

Зураг №2,3 Хорих ангийн шашны зан үйлийн өрөө



Улсын хэмжээнд нийт 20 хорих анги үйл ажиллагаа явуулж байгаагаас бүх хорих анги нь буддын шашны зан үйл үйлдэх өрөөг тохижуулсан байдаг байна.

“Хоригдлын шашин шүтэх, эс шүтэх эрхийн хэрэгжилтийн талаарх судалгаа”-ны үр дүнд хорих ангийн шашны зан үйл үйлдэх өрөө хоригдлын хэрэгцээ шаардлагад хангалттай нийцдэг эсэхийг тандахад нийт хоригдолын 59.3% нь нийцдэг, 40.6% нийцдэггүй гэж хариулсан нь мөн л нийт хоригдлуудын дунд буддын шашинтан хоригдлуудын хувь хэмжээ их байдаг, шашны зан үйлийн өрөө нь буддын шашны хэв маягаар тохижуулагдсан мөн хорих ял эдлүүлэх ажиллагааны дэг журамтай байдалтай холбоотой байж болох юм.

Энэ нь буддын шашинтай хоригдлуудын хувьд шашин шүтэх эрх чөлөөг нь эдлүүлэх боломжоор хангасан ба Христ, Ислам, Хинду болон бусад шашинтай хоригдлуудын эрхийг хангахгүй байна.

Судалгааны хүрээнд хоригдлууд шашны зан үйл үйлдэхэд хүндрэлтэй асуудлуудыг тодруулахад тогтсон цагийн хуваарь байхгүй (35 хувь), шүтдэг шашны урсгалын хэрэглэгдэхүүн байхгүй (27.6 хувь), өрөөний тохижилтоос болж зан үйл үйлдэх боломжгүй (20.1 хувь), цөөхөн хүний багтаамжтай учраас багтдаггүй (17.1 хувь) гэх судалгааны үр дүн гарсан юм.

Эдгээр бэрхшээлүүд нь хоригдлуудын шашны зан үйлээ гүйцэтгэхэд тодорхой бэрхшээлүүдийг дагуулдаг бөгөөд нийт судалгаанд оролцогч нарын 27.6% нь шүтдэг шашных нь хувцас, эдлэл, хэрэглэл байхгүй байгаатай холбоотойгоор эрх нь зөрчигдөж байна гэж үзсэн.

Нийт хоригдлын хувьд авч үзвэл хоригдлын шашин шүтэх эрхийг хангаж байгаа боловч бусад шашин шүтдэг хоригдолд өөрийн итгэж үнэмшдэг шашны зан үйлийг үйлдэх боломжгүй, оюун санаа, сэтгэл зүйн хувьд тайвширах, бясалгах нөхцөлийг хангахгүй байх нь хорих ялаар дамжуулан хүмүүст сэтгэл зүйн дарамт, үл хүндлэгдэх, хүлээн зөвшөөрөгдөхгүй байх мэдрэмжийг төрүүлж байна. Мөн

хорих ангийн үйл ажиллагааны зохион байгуулалт буюу хорих ангийн дотоод цагийн хуваарь нь уг эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байх нөхцөл бүрдүүлж байна.

Эрх чөлөөгөө хасуулж нийгмээс тусгаарлагдсан ч тэдний оюун санааны эрх чөлөө, шашны итгэл үнэмшил, сүсэг бишрэлээ хадгалах, итгэн үнэмших, амар амгаланг мэдрэх тэрхүү боломж, эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа нь хувь хүний хүмүүжил, төлөвшилд ноцтой хор уршиг учруулж болно.

Тухайлбал, Бэйлорын их сургуулиас хийсэн судалгаагаар¹ шорон дахь шашны үйл ажиллагаа нь криминологийн судалгаанд хувь нэмэр оруулж, нийгэмд эерэг хандлагыг төлөвшүүлэх, хоригдолын хувийн гэмт зан үйл, шинж чанарыг өөрчлөхөд тусалдаг бөгөөд суллагдсаны дараа дахин нийгэмшихэд чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэсэн байна. Дэлхийн бусад улс орны хорих ангиуд хоригдлуудын шашин шүтэх, эс шүтэх эрхийг хамгаалах үүднээс шашны зан үйл үйлдэх өрөөгөө хоригдлын янз бүрийн шашны зан үйл үйлдэхэд боломжтой байдлаар тохижуулсан байдаг ба шашин болгон өөрийн гэсэн онцлог, хэрэглэгдэхүүн, үзэл, номлол, сургааль, зан үйлтэй тул тэд ихэвчлэн төвийг сахисан буюу аль нэг шашны хэрэгсэлийг байршуулж тохижуулахаас илүү орчин, тав тухыг сайтар хангасан, олон урсгалын шашны ном, судруудыг багтаасан, хувийн орон зай, дуу чимээний тусгаарлагчтай, аюулгүй байдлыг хангасан байдлаар тохижуулсан байдаг байна.

Америкийн Нэгдсэн улсын Хууль зүйн яамны хийсэн судалгаагаар² сэтгэл санаа, ёс зүйтэй холбоотой дэмжлэг авсан хоригдлуудын дахин гэмт хэрэг үйлдэх магадлал 10-20% хүртэл буурдаг ба шашин шүтлэгтэй хоригдлууд сэтгэл санааны хувьд илүү тогтвортой байж, цөөн зөрчил гаргадаг болохыг тогтоосон байна. Тус улс нь хоригдлууд нь шашны зан үйлээр дамжуулан сэтгэл санааны тогтвортой байдал, нийгэмшилт, үнэт зүйлс, ёс суртахууны мэдрэмж, гэмшил, хариуцлага хүлээх ухамсрыг олж явдаг гэж үздэг.

Америкийн нэгдсэн улсын хувьд хоригдлуудын шашин шүтэх, эс шүтэх эрхийг Үндсэн хууль, Шашны эрх чөлөөг хамгаалах тухай хууль (Religious Freedom Restoration Act, RFRA), мөн Шашны газар болон институцийн хүмүүсийн эрхийн тухай хуулиар (Religious Land Use and Institutionalized Persons Act, RLUIPA) зохицуулдаг. 1993 онд батлагдсан Шашны эрх чөлөөг хамгаалах тухай хууль

¹ Byron R. Johnson, “How Religion Contributes to the Common Good, Positive Criminology, and Justice Reform”. 2021. <https://www.mdpi.com/2077-1444/12/6/402>

Судалгаанд шашин нь хоригдлуудын амьдралд хэрхэн эерэгээр нөлөөлж, нийгмийн сайн сайхны төлөө ямар үүрэг гүйцэтгэж байгааг шинжилсэн байдаг. Судалгаагаар шашин шүтлэг, ялангуяа сүсэгтэн сайн дурынхан болон шашны байгууллагуудын оролцоо нь гэмт хэргийн давталтыг бууруулах, засаж хүмүүжүүлэх үйл явцыг дэмжихэд ихээхэн нөлөөлж байгааг харуулжээ. Шашны зан үйл нь хоригдлуудад ёс суртахуун, өөрийгөө хянах чадвар, өөрчлөгдөх боломжийг олгож, дахин гэмт хэрэг үйлдэх магадлалыг бууруулахад тусалдаг гэж үзсэн байна.

² АНУ-ийн Хууль зүйн яамны хийсэн судалгаа. <https://www.ojp.gov/>

(RFRA)¹ нь төрийн байгууллагуудад шашны эрх чөлөөнд саад болохоос зайлсхийх үүргийг хүлээлгэсэн байна.

АНУ-ын хорих ангийн систем нь хоригдлын шашин шүтэх эрхийг хүлээн зөвшөөрч, шашны зан үйл үйлдэх боломжийг олгож, тэдгээрт шашны итгэл үнэмшилд нийцсэн хоолны сонголтыг санал болгох, шашны удирдагч зөвлөхтэй уулзуулах, шашны итгэл үнэмшилтэй холбоотой эд зүйлсийг хангаж өгөх зэрэг байдлаар хоригдлын эрхийг хангаж, аюулгүй байдлыг хамгаалан ажилладаг болохыг анхаарах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Хүний оюун санаа, нийгмийн хөгжил хөдөлгөөнийг тодорхойлогч томоохон хүчин зүйл нь шашин шүтэх, эс шүтэх эрхээр дамжин хэрэгждэг бөгөөд нийгмийн суурь харилцааны нэг болох нь харагдаж байна. Иймд шашин шүтэх эрх чөлөөг хангах, бэхжүүлэх явдал нийгмийн бүхий түвшинд зайлшгүй анхаарч хүлээн зөвшөөрөх ёстой болохыг олон улсын болон дотоодын эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлогджээ.

Дэлхий дээр нийт 4000 гаруй шашны урсгал байдаг ба Монгол Улсын хувьд Буддын шашин, Христийн шашин, Исламын шашнуудын чиг хандлага давамгайлдаг бөгөөд сүүлийн жилүүдэд Тэнгэр шүтлэг буюу Бөөгийн зан үйлийг түлхүү хэрэглэх болсон. Шашин шүтлэгийн хамгийн чухал зүйл бол итгэл үнэмшлийнхээ хүрээнд тодорхой цаг хугацаанд, орчин нөхцлөө бүрдүүлэн сүсэглэн залбирах, мөргөл үйлдэх зэрэг шашны онцлогийг шингээсэн итгэл үнэмшил бүхий зан үйл үйлдэх явдал байдаг.

Хорих ял эдлэх нь тухайн хүнийг нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх үндсэн зорилгыг агуулж байгаа бөгөөд түүнд үзүүлэх шашны нөлөө хоригдлын засрал хүмүүжил, сэтгэл зүйн тогтвортой байдлыг дэмжихэд ихээхэн оролцоотой болох нь харагдаж байна.

Хорих ял эдэлж буй хүмүүсийн дунд олон төрлийн шашны үзэл хандлага, итгэл үнэмшил бүхий хүмүүс байгаа нь хорих байгууллагад хоригдлын эрхийг хангасан хэд хэдэн төрлийн шашны зан үйлийг хэрэгжүүлэх боломж нөхцөл бүрдүүлэх ёстойг тодорхойлж байна.

Хорих ангийн шашны зан үйл үйлдэх өрөөг бүх урсгалын шашны зан үйл үйлдэх нөхцөл боломжоор хангаагүй, нэг төрлийн шашны урсгалыг дагнаснаараа бусад хоригдлын шашин шүтэх эрхийг зөрчиж, хүндэтгэлгүй хандсан нь иргэдийн эрхийг хангагч төрийн иргэдийгээ шашин шүтлэгээр ялгаварлахгүй хүндэтгэлтэй

¹ Religious Freedom Restoration Act of 1993. <https://www.congress.gov/bill/103rd-congress/senate-bill/578>

хандах үүргийн зөрчил гэж харж болох юм. Уг боломж нөхцөлөөр хангаагүйгээс хүний эрхийн ноцтой зөрчил хорих ял эдлүүлэх ажиллагаанд бий болсоор байна.

САНАЛ

Нэг. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Ламтай хоригдол уулзах боломжийг хязгаарлаж болохгүй талаар ШШГТХ-д тусгах

2. Шашны зан үйл үйлдэх цагийн хуваарь, зохицуулалтын талаар хорих ангийн дотоод журам эсвэл холбогдох бусад дүрэм журамд тусгах.

3. Шашны төлөөлөгч лам, номлогч нартай тогтмол уулзах боломжоор хангах, тэдгээрийн уулзалтын талаар эрх зүйн зохицуулалт тусгах

4. Хорих ангийн шашны зан үйлийн өрөөний стандартыг тогтоох

Хоёр. Шашны зан үйл үйлдэх өрөөг төвийг сахисан байдлаар буюу олон шашны зан үйл үйлдэх боломжоор хангаж тохижуулах:

5. Хоригдлын хувийн орон зай, дуу, чимээний тусгаарлалт хийж төвлөрөх боломжийг олгосон байх

6. Залбирал, бясалгал хийхэд зориулагдсан сандал, дэвсгэр зэргийг байрлуулах

7. Шашны номлол, сургаалыг авч үзэх боломжоор хангасан байх

8. Шашны төлөөлөгч ламтай ганцаарчлан уулзах боломжоор хангах

9. Олон төрлийн шашны ном, сурах бичгийн хэрэгцээг хангах номын фондтой байх.